

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

2026 оны үйл ажиллагааг төлөвлөхдөө гадаад болон дотоод орчны нөлөөллийг харгалзан үзсэн бөгөөд улс төр, макро эдийн засгийн орчинд огцом өөрчлөлт гарахгүй гэж тооцвол энэхүү бизнес төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд саад болохуйц томоохон эрсдэл байхгүй гэж үзэж байна.

Төлөвлөгөөнд 2026 онд өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс **132%-иар их буюу 17.9 сая тонн ачаа, 106.8 %-иар давсан 583.5 тэрбум төгрөгийн орлого, 129% -ийн өсөлттэй 550.0 тэрбум төгрөгийн зардал, 29.2 тэрбум төгрөгийн цэвэр ашиг** тайлант онд бий болгохоор тооцоолсон. Энэ нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, бүтээмж болон үр ашгийг бодитойгоор нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Орлогын тухайд нийт орлогын дийлэнх 57% -ыг “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлд “Чайна-Энержи” ХХК -ын урт хугацааны нүүрс тээвэр эзэлж байгаа нь урт хугацаандаа компанийн орлого тогтвортой байх нь харагдаж байна.

Зардлын тухайд нийт зардлын өсөлт өмнөх оноос 129 хувиар өсөлттэй байгаа боловч 2026 оны нийт зардалд үндсэн үйл ажиллагааны зардал 77.5 хувь, үндсэн бус үйл ажиллагааны зардал 0.7 хувь, элэгдлийн зардал 8.5 хувь, санхүүгийн зардал 13.4 хувийг тус тус эзэлж байна.

Нийт **55.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв** төлөвлөснөөс **95% нь орон нутагт** чиглэж байгаа нь тээвэрлэлтийн тасралтгүй ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдал, зам талбайн арчилгааг хангахад чухал ач холбогдолтой.

Ийнхүү хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө төмөр замын тээврийн үйл ажиллагааг **тасралтгүй, аюулгүй, найдвартай** байлгах, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, цаашдын тогтвортой өсөлтийг хангах зарчмыг баримталсан. Мөн үйл ажиллагааны орлогоос боломжит хэмжээгээр хөрөнгө оруулалтыг жил бүр тасралтгүй хийх бодлогыг сахин ажиллах нь компанийн дунд хугацааны хөгжлийн суурь нөхцөл болж байна.

Энэхүү бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулахаас гадна байгууллагын **хүний нөөцийн чадавх, хөдөлмөрийн бүтээмж, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, үр ашгийн түвшин** сайжирч, үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөний хүрээнд бууруулж, ашигт ажиллагааг тогтвортой өсгөх стратегийн ач холбогдолтой юм